

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
ЭНХТАЙВАН ОВОГТОЙ АЛТАНЗУЛЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биел элт (хувь)
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “ОЛОН УЛСЫН ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, ТҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 1.1 Гаалийн хяналтад эрсдэл тооцох	Хэрэгжилт, гүйцэтгэл ээр	-	1. Өөрийн хариуцсан газар хорооны эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд оруулна. 2. Гаалийн хяналтад эрсдэл тооцож дүн шинжилгээ, судалгаа хийж, үр дүнг тооцно.	Хариуцсан ГГХ-оос ирүүлсэн ЭУ-ын тайлан, гадаад худалдааны судалгаа, төлөвийн дүн шинжилгээ болон шалгуурын судалгаа, ГУБ-ын ШҮД-ийн судалгаатай тухай бүр танилцан, удирдлагад мэдээллээр ханган, холбогдох зөвлөмж, чиглэлийг хүргэж ажиллав. “Гадаад худалдааны орчны судалгаа 2018-2022”-ыг хийсэн загварын дагуу тухайн гаалийн газар, хорооны хяналтын объектыг харуулсан 2021-2023 оны судалгааг хийж, эрсдэлт орчноо тодорхойлоход дэмжлэг үзүүлсэн. Үр дүн: Хариуцсан ГГХ-тай ЭУ-ын чиг үүргийн хүрээнд тогтмол хамтран ажиллаж, хэлтсийн даргыг мэдээллээр хангаж байна. Харьяа гаалийн газар, хороод өөрийн хяналтын объектод эрсдэл тооцон, “Эрсдэлийн удирдлагын программ”-д оруулах шалгуур үзүүлэлтийг эрсдэлийн зэрэглэлээс үл хамааран оруулах чиглэлийг хүргүүлсэн. Үүний үр дүнд хариуцсан Замын-Үүд дэх гаалийн газар 2 удаагийн албан бичгээр 8 шалгуурын хүсэлт ирүүлсэн. Үр дүн: 7 хяналтын хуудсаар 8 эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулж, программд оруулж баяжилт хийсэн. Гаалийн хяналтад эрсдэл тооцож дүн шинжилгээ, судалгаа хийв. Үүнд: 1. “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ын гаалийн бүрдүүлэлтийн эрсдэлийн судалгаа,	2024.01.01-06.05	100

					2. ЭРЧИС ОЙЛ ТӨХХК-ийн гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэлд хийсэн эрсдэлийн дүн шинжилгээ, 3. БТКУС-ийн 8703 ангиллын кодоор бүрдүүлэлт хийсэн хууль сахилт сайн аж ахуйн нэгжийн дүн шинжилгээ, 4. БТКУС-ийн 6907.40.00, 6809.90.00, 6809.19.00 ангиллын кодыг эрсдэлийн удирдлагын “Заавал шалгах” шалгуурт оруулах дүн шинжилгээ, 5. “БТКУС-ийн 4011 ангиллын код” хийлдэг, шинэ хаймар дугуй импортын бүрдүүлэлт хийсэн 16 аж ахуйн нэгжийн дүн шинжилгээ, 6. ЗҮГГ-ын “Хууль сахилтын түвшин өндөр” ААН-ийн дүн шинжилгээ, 7. ЗҮГГ-аар БТКУС-ийн 8711.20.11 ангиллын кодоор бүрдүүлэлт хийсэн “Хууль сахилтын түвшин өндөр” ААН-ийн дүн шинжилгээ, 8. БТКУС-ийн 23 бүлэг, 1214 зүйлийн ангиллын кодоод хамаарах бараа, бүтээгдэхүүн импортлоход хорио цээрийн эрсдэлийн дүн шинжилгээ, 9. Цахимаар худалдан авсан програм хангамж, зураг төсөл, кино, контент зэрэг биет бус барааны дүн шинжилгээ, 10. ХЦ-ийн эрсдэл бүхий 121 барааны дүн шинжилгээ, 11. Засгийн газрын 2015 оны 332 болон 2016 оны 185 дугаар тогтоолд хамаарах өндөр тарифтай барааг бага тарифтайгаар мэдүүлэх магадлал бүхий барааны дүн шинжилгээ, 12. БТКУС-ийн 2304.00.00 ангиллын кодын барааны дүн шинжилгээ, 13. Гаалийн хорио цээрийн хэлтсээс ирүүлсэн “2023 оны лабораторийн шинжилгээт хяналтаар илэрсэн зөрчил”-тэй барааны дүн шинжилгээ, 14. Гаалийн газар, хороодын салбар лабораторийн 2023 оны эерэг сорьцын судалгааны мэдээлэлд үндэслэн “дээжний гадаад, дотоод хорио цээртэй” барааны дүн шинжилгээ-1; 2; 3; 4. 15. Гаалийн хяналтын сонгон шалгах хувь хэмжээ өөрчлөх судалгаа, дүн шинжилгээ, 16. ГЕГ-ын БЦТ-ийн 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 58 дугаар дотоод зурвас “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүснэгт”-ээр ирүүлсэн ААН-ийн дүн шинжилгээ, 17. “Шуурхай хяналтын төв”-ийн 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 49 дугаар дотоод зурвасын хавсралт “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүснэгт”-ээр ирүүлсэн ААН-ийн дүн шинжилгээ,		
--	--	--	--	--	---	--	--

					18. ХЦХ-ийн 2024.05.02-ны 147 дугаар дотоод зурвас "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийн БТКУС-ийн ангиллын кодуудын дүн шинжилгээ, 19. Юнайтед мерес машинери ХХК /ГХО/-ын дүн шинжилгээ. Үр дүн: Хяналтын хуудсын нийт 19 судалгаа, дүн шинжилгээ, танилцуулгыг хийж, хяналтын хуудас боловсруулж ЭУ-ын программд оруулсан. Боловсруулсан шалгуурын 44.3 хувь "Зөвшөөрөгдсөн шалгуур", 25.9 хувь "Заавал шалгах шалгуур", 15.7 хувь "Өндөр эрсдэлийн шалгуур" үлдсэн хувийг бусад шалгуур эзлэсэн байна.		
				3. Эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд оруулна.	Эрсдэлийн удирдлагын программын мэдээллийн санд 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 10-ны хугацаанд 95 хяналтын хуудсаар 483 шалгуур үзүүлэлтийг боловсруулж, оруулсан байна. Үүний 48 хяналтын хуудсаар 79.9% буюу 386 шалгуурыг дангаар боловсруулсан байна. Эрсдэлийн шалгуурын 44.3 хувь "Зөвшөөрөгдсөн шалгуур", 25.9 хувь "Заавал шалгах шалгуур", 15.7 хувь "Өндөр эрсдэлийн шалгуур" үлдсэн хувийг бусад шалгуур эзлэсэн байна. Үр дүн: Дээрх шалгуурыг боловсруулж, бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт мэдүүлгийн 63.1%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 3.5%-иар өссөн эерэг статистик үзүүлэлттэй байна.		
2	Хууль сахилтын удирдлагын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлхийн	Хэрэгжилт, гүйцэтгэл ээр	-	1. Хяналтын төлөвийн хэрэгжилт, төлөв солилтын шалтгаан үр дүнг тооцно.	1. Хяналтын төлөвийн хэрэгжилтийн судалгааг өдөр бүр, долоо хоног, сар, өссөн дүнгээр хэрхэн хийх форматыг гарган харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан ГУБ нарт хүргүүлж, системийн хэмжээнд нэг загвараар гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж ажиллав. Мөн СТ-т холбогдох маягтын дагуу сар бүр хүргэж ажилласан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд гаалийн системийн хэмжээнд 505235 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс импортын 180613 (35.7%), экспортын 324622 (64.3%) гаалийн бүрдүүлэлт хийгдсэн байна. Нийт бүрдүүлэлтээс 1294 гаалийн мэдүүлгийг засварт буцаасан нь нийт бүрдүүлэлтийн 0.3%-ийг эзэлж, 717 мэдүүлгийг "баталгаажихаас өмнө", 577 мэдүүлгийг "баталгаажсаны дараа" тус тус засварт буцаасан байна (Гаалийн мэдүүлгийн засвар буцаалт нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 89 мэдүүлгээр буурсан үзүүлэлттэй).	01.01-06.05	95

	тулд хууль сахилтын эрсдэлийн удирдлагын программын даалгавар боловсруулна.			2. Хууль сахилтын эрсдэлийн удирдлагын загварыг боловсруулсан байна.	Тайлант хугацаанд хийгдсэн 505235 бүрдүүлэлтээс хяналтын “ногоон” төлөвийн 9, “улбар шар” төлөвийн 27 буюу нийт 36 мэдүүлгийн төлөвийг “Улаан” төлөвд өөрчилсөн нь өнгөрсөн оны үеэс 6 дахин буурсан байна (2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хийгдсэн 387313 бүрдүүлэлтийн хяналтын “ногоон” төлөвийн 20, “улбар шар” төлөвийн 193 буюу нийт 213 мэдүүлгийн төлөвийг өөрчилжээ). Тус өөрчлөлтийг тухай бүр холбогдох гаалийн газар, хороодоос тодруулж, удирдлагад танилцуулан ажиллав. Эрсдэлийн удирдлага хариуцсан ГУБ нар мэдүүлэг засварт буцаалтад дүн шинжилгээ хийж, бичиг баримтын болон хяналт хариуцсан ГУБ нарт зөвлөмж, чиглэл өгч ажилласнаар үндэслэл муутай төлөв өөрчлөх, мэдүүлэг засварт буцаах эрсдэл буурсан. Үр дүн: Нийт 36 төлөвд өөрчилсөн нь өнгөрсөн оны үеэс 6 дахин буурсан байна. 2.Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд гадаад худалдаанд оролцогч хуулийн этгээдийн хууль сахилтын түвшинг тогтоох зайлшгүй шаардлагатай тул Хуулийн этгээдийн хууль сахилтын түвшинг тодорхойлох загварыг боловсруулан Мэдээллийн технологийн газарт Кайс программд оруулахаар программын даалгавар хүргүүлсэн. Мөн эрсдэлийн удирдлага дэд программын “Эрсдэлийн мессеж сан” цэсэнд өөрчлөлт оруулахаар харьяа гаалийн газар, хорооны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж, албан хаагчдаас санал авч нэгтгэсэн. Холбогдох программын даалгаврыг боловсруулж, МТГ-т хүргүүлсэн. Үр дүн: МТГ-аас программын даалгаврын дагуу холбогдох өөрчлөлтийг хийж байна.		
3	Гадаад худалдааг хөнгөвчлөх ажлын хүрээнд гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх		-	1. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, ЗББНДБ, гаалийн газар, хороодтой хамтран ажиллана.	1. Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөн ажлын хэсгийн тушаалыг шинээр батлуулсан. Гаалийн байгууллагын худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн 2024 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Түүнчлэн Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн ажилд хяналт тавих зорилгоор Reform Tracker программыг ашиглаж эхэлсэн. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын худалдаа хөгжлийн бага хуралтай хамтран ажиллах цахим уулзалтуудыг зохион байгуулсан.	01.01-06.05	91

	хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулсан арга хэмжээг зохион байгуулна.			2.Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажилласан байна. 3.Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулсан арга хэмжээг зохион байгуулна.	Үр дүн: Меркатор хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө мөн Хямралын үед Худалдааг хөнгөвчлөхөд бэлэн байдлын үнэлгээний тайлан, үйл ажиллагаа зэргийг Reform tracker программд оруулж, ашиглаж эхэлсэн нь Худалдааг хөнгөвчлөх ажлын шинэчлэлтийг сайжруулах ахиц, дэвшил болсон. 2. Итгэмжлэгдсэн ААН-ийн харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсан улс болох БНХАУ болон БНСУ-ын гаалийн байгууллагатай хэлэлцээрийг цаашид хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөөт цахим уулзалтуудыг зохион байгуулсан. Тус хоёр оронтой цахимаар тогтмол мэдээлэл солилцож ажилласан. Мөн Оросын холбооны улсын гаалийн байгууллагатай Итгэмжлэгдсэн ААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах ажлын хүрээнд цахим уулзалтуудыг хийж, бэлтгэл ажлын ханган ажилласан. Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай хэлэлцээрийн 2 талын шинжээчдийн анхдугаар уулзалт 2024 оны 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулж, талууд Монгол-Оросын талын худалдааны хүрээнд хилээр нэвтрүүлэх барааны эрсдэлийг бууруулахад ач холбогдол бүхий мэдээллийг солилцох, хэлэлцээрийг хэрэгжүүлэх хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг тохиролцсон. 3.Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC)-ийн хүрээнд Гаалийн Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН)-ийн хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинар 2024 оны 4 сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан. Энэ семинарын зорилго нь худалдааг хөнгөвчлөх нэгдмэл стратегиудыг бий болгох, гаалийн хяналтыг оновчтой хэрэгжүүлэхэд чиглэсэн Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийн үндсэн зарчмуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, сургагч багш бэлтгэхэд чиглэгдсэн. Энэхүү арга хэмжээнд Хувийн хэвшил, Гааль, ГХЯ, ЭЗХЯ, хөгжлийн түншлэгч байгууллагын 60 оролцогчдыг хамруулсан. Гаалийн байгууллагын цахим сайт болон FB Монголын гааль хуудсаар сурталчилж ажиллав.		
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1	Арга хэмжээ 1.2 Бодлогын баримт бичгийн	Хэрэгжилт,	-	1. Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй	1. ГЕГ-ын даргын 2022 оны А/343 дугаар тушаалаар “Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын стратеги”, хорио цээрийн болон гаалийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор	01.01-06.05	91

	зорилт, арга хэмжээний хэрэгжилт	гүйцэтгэл ээр		болгох зорилгоор Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулж, төслийг боловсруулсан байна. 2. Эрсдэлийн удирдлагын чиглэлээр холбогдох бусад бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайлагнасан байна.	“Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журмыг шинэчлэхээр ажиллаж байна. Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулах төслийг боловсруулж, ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодод төслийг хүргүүлж холбогдох саналыг тусган, 6 удаагийн уулзалт хийж, эцсийн хувилбарыг боловсруулсан. 2.Засгийн газрын 2023.05.17-ны өдрийн 178 дугаар тогтоолын биелэлтийг дараах заалтуудын дагуу Хуулийн хэлтэст сар бүр, Хяналт, бүрдүүлэлтийн газарт Нэгдүгээр улирал болон 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус тус гаргаж, цаг хугацаанд нь хүргүүлсэн: - Эрсдэлд суурилсан гаалийн хяналтыг эрчимжүүлж, мэдээлэл, бичиг баримтын болон бараа, тээврийн хэрэгсэлд хийх шалгалтад хамрагдах гаалийн бүрдүүлэлтийн тоог жил бүр 15 хувиар бууруулж, гадаад худалдааг хөнгөвчлөх, хилийн боомт дээр дараалал, бөөгнөрөл үүсгэхгүйн тулд бараа, тээврийн хэрэгслийг гүнийн гаалийн хяналтад шилжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах; - Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гаалийн байгууллага хооронд байгуулсан “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх; - “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуй нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”-д заасан аж ахуйн нэгжид тавигдах шаардлагыг оновчтой болгох, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах. - Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 178 дугаар тогтоол , Гаалийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт зэрэг бодлогын бичиг баримт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зөвлөмжийн дагуу биелэлтийг гаргаж, цаг хугацаанд нь тайлагнасан.		
--	--	------------------	--	--	---	--	--

2	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэхэд хэлтсийн албан хаагчидтай хамтарч ажилласан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэл ээр	-	1.Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэсэн байна. 2.Эрсдэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.	"Эрсдэлийн удирдлагын хэлтсийн үйл ажиллагааны эрсдэлийн дүн шинжилгээ"-г нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хийж гүйцэтгэв. Үүнд: - Хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүргийн харьцуулалт; - Үндсэн ажлаас гадуур болон цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн ажил; - Ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа албан хаагчдын үндсэн мэргэжил, ур чадвар, гүйцэтгэл, ажлын цаг ашиглалт, илүү цаг болон бусад дотоод ажил; - Гүйцэтгэлийн тайлан, ХШҮДАГ-аас ирүүлсэн зөвлөмж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт; - Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, гадаад орны гаалийн байгууллагатай хамтран ажилласан байдал гэсэн мэдээлэлд үндэслэн ДГБ-ын "Эрсдэлийн удирдлагын компендиум", Олон улсын стандартын байгууллагын "Эрсдэлийн удирдлагын зарчим ба стандарт", холбогдох үндэсний хууль тогтоомжтой уялдуулан хийж гүйцэтгэсэн. Үр дүнд: Өмнөх жилүүдэд нэгжийн эрсдэлийг ерөнхий байдлаар тооцож байсан боловч, олон улсын стандартад үндэслэн эрсдэлийн агуулгыг тодорхойлохоос эхлэн түүнийг бууруулах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангах иж бүрэн судалгаа хийж байгаагүй. Энэ жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэхүү ажлыг тусгасан нь тус хэлтэс өөрийн эрсдэлт орчныг таньж, тодорхойлж, түүнийг бууруулах боломжийг гарган ирсэн нь үр дүнтэй ажил болсон. Гаалийн газар, хороодын орчны судалгаа. “Гадаад худалдааны орчны судалгаа 2018-2022”-ыг хийсэн загварын дагуу тухайн хариуцсан гаалийн газар, хорооны хяналтын объектыг харуулсан 2021-2023 оны судалгааг хийж, эрсдэлт орчноо тодорхойлоход дэмжлэг үзүүлсэн. ЗҮГГ, СЭГГ, ХАГГ-т ГУБ-ын шалгалтын үр дүнгийн саналд хэрхэн дүн шинжилгээ хийхэд зөвлөмж, чиглэл өгч ажилласан. Мэдүүлэг буцаалт, гаалийн хяналтын төлөв өөрчлөлтөд хэрхэн дүн шинжилгээ хийх тухай зөвлөмжийг өгч ажиллав.	01.01-06.05	100
---	---	--------------------------	---	---	---	-------------	-----

3	ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан байна.	2024 оны 2 дугаар сарын 15-ны дотор 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг үнэн зөвөөр мэдүүлж, ЗУГ-ын эрх бүхий албан тушаалтанд гаргасан.	01.01-06.05	100
4	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	Хэлтсийн даргын хуваарилсаны дагуу тс хэлтсийн “Зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлт”-ийг тайлагнав. 1. ЗУГ-ын “Үүрэг даалгавар” - 2024.01.09-11.30, - 2024.02.02-03.31 - 2024.03.06-03.12 2. ХШҮДАГ-ын “Зөвлөмж” - 2023.12.28 - 2024.04.10-06.10. 3. Эрсдэлийн удирдлагын программын мэдээллийн санд оруулсан шалгуурын мэдээ (2024 оны 01 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 10-ны хугацаанд) 4. ЭУХ-ийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн: - Эрсдэлийн мэдээллийн сан үүсгэх, судалгаа дүн шинжилгээ хийх, - Эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд оруулах, - Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт, - Харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлэх, - Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг тухай бүр нүүр таних програмд бүртгүүлж, ажлын шаардлагаар илүү цагаар ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулах.	01.01-06.05	95

				2.ХГГХ-д хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.	Хэлтсийн үйл ажиллагааны ЭУ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, ЗГ, СЯ болон бусад байгууллагаас баталсан төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж ажиллав. - ЗГ-ын 178 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг сар бүр, ХШУДАГ-ын зөвлөмжийн тайланг тухай бүр гаргасан. - ЭУ-ын шалгуурын хэрэгжилтийг хангаж ажиллав. - Хариуцсан харьяа ГГХ-ын шалгуур, үүрэг даалгаврын биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав. -Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, удирдлагаар батлуулсан. 2.Хариуцсан гаалийн газар, хорооны эрсдэлийн удирдлагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад зөвлөмж, чиглэлээр хангасан. Тус нэгжээс харьяа гаалийн газар, хороонд өгсөн үүрэг даалгаврыг хянаж, хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн.		
5	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Ажлын цаг ашиглалтыг тухай бүр нүүр таних програмд бүртгүүлж, ажлын шаардлагаар илүү цагаар ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулсан байна.	Ажлын цаг ашиглалтыг тухай бүр нүүр таних программд бүртгүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж ажиллав. 2024 оны эхний хасгас жилийн байдлаар 112 хүн өдөр буюу 896 цаг ажиллахаас бүрэн ажилласан байна. Томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцсон үед чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулж,	01.01-06.05	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
6	Шаардлагатай тохиолдолд үндсэн шалгуурт тусгагдаагүй	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байдлыг тайлагнасан байна.	Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Монгол Улсын Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024.03.22-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан. Уг хороонд “Оюуны өмчийн эрх”-ийн бүлэгт багтаж, ажилласан.	01.01-06.05	95

	бусад чиг үүргийг хэрэгжүүлж, тайлагнасан байна.				ГЕГ-ын Худалдааг хөнгөвчөх ажлын хэсгийг ГЕГ-ын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан дахин шинэчилж, 2024 онд байгуулсан бөгөөд уг ажлын хэсгийн нарийн бичгээр Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ГУАБ ажиллахаар батлагдсаны дагуу ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж байна. Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж ГЗДАСистемд оруулсан бөгөөд 114 албан хаагч танилцсан. Батлагдсан төлөвлөгөөтэй 157 албан хаагч танилцаж, өөрийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. ЭУХ-ийн бичиг хэргийн бүртгэлийг хариуцан ажиллав. ЭУХ нь 2023 оны эхний 6 сарын байдлаар нийт 16 нэгжтэй 168 дотоод зурвасаар харьцсан байна. Үүнээс надад хуяарилагдсан 56 буюу 33.3%, ирсэн 192 дотоод зурвасын 42 буюу 22%-ийг хүлээн авч холбогдох арга хэмжээг авч ажилласан. Ирсэн 93 албан бичиг ирсэнээс 29-ыг хүлээн авч хариуцан шийдвэрлэсэн ба явсан 12 албан бичгийн 2-ыг боловсруулан батлуулж ажилласан байна. Мөн 2024 онд архивт өгөх хадгаламжийн нэгжээс одоогийн байдлаар өмөнх оны ЭУ-ын чиг үүргийн холбогдолтой 22 баримтыг бэлтгэн архивт хүлээлгэн өгөв. Үр дүн: Өөрт хуваарилагдсан бичиг, баримтыг боловсруулж, бүрэн гүйцэтгэсэн.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Гаалийн байгууллагаас зохион	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Төрийн албан хаагчдын Анхан шатны	Гадаад, дотоод сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	1. Мөнгө угаахтай тэмцэх мөрдөн шалгалт хийх арга техникийн семинар. Хугацаа: 2024.04.08-10 - Зохион байгуулсан газар: Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ), ГЕГ-ын ЗТГ. 2. “Стандартчиллын суурь асуудлууд” сэдэвт сургалт	2024.01.01 -06.05	100

байгуулж буй сургалтад тухай бүр хамрагдах		мэргэш үүлэх сургалт ад хамрагд сан.		Хугацаа: 2024.05.21. Зохион байгуулсан газар: ГЕГ-ын ХЦХ болон Стандарт, хэмжил зүйн газрын хамтарсан. 3. ГИААН-ийн хөтөлбөрийн сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинар. Хугацаа: 2024.04.29-05.02 Зохион байгуулсан газар: Төв Азийн бүс нутгийн ЭЗ-ийн хамтын ажиллагааны хүрээнд (CAREC), ГЕГ-ын ЭУХ. 4. ГЕГ-ын ЗББНДБ-ын дунд 14 хоногт нэг удаа зохион байгуулагддаг нийт 9 удаагийн мэдээллийн цагт оролцож, дараах сургалтад хамрагдав. - Олон улсын гаалийн өдөр 2024 - АТГ - Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргахад анхаарах зарим асуудал" - Монголын хөрөнгийн бирж – "Үнэт цаас болон уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа" - "Интерактив" ХХК-"Дата менежмент, хэрэглээ, ач холбогдол" - Иргэдийн боловсролын төв – Хүн амын хоол тэжээлийн асуудал - Байгууллагын сэтгэл судлаачдын хөгжлийн нийгэмлэг - "Ажлаас халшрах хам шинж- сэтгэл судлал" - ГЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс - "Гаалийн байгууллагын дотоод хяналтын чиг үүрэг, ойлголт", - Эрүүл мэндийн даатгалын газар -"Эрүүл мэндийн даатгалын талаарх ойлголт" - Сансар зуслангийн хөтөлбөр, маркетингийн алба - "Сансар, Шонхор" зуслангийн танилцуулга - Эрсдэлийг удирдах байгууллагын соёл		
---	--	---	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
(Албан тушаал)

Э.АЛТАНЗУЛ/  /
(Нэр, гарын үсэг)

2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр
(Огноо)

**Эрсдэлийн удирдлагын хэлтсийн гаалийн улсын байцаагч
Энхтайван овогтой Алтанзулын
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Нэгжийн нэр: ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70хүртэл	
Зорилт 1. "ОЛОН УЛСЫН ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, ТҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1. Гаалийн хяналтад эрсдэл тооцох	55	10	65	
2.	Арга хэмжээ 1.2. Хууль сахилтын удирдлагын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлхийн тулд хууль сахилтын эрсдэлийн удирдлагын программын даалгавар боловсруулна.	54	9	63	
3	Арга хэмжээ 1.3. Гадаад худалдааг хөнгөвчлөх ажлын хүрээнд гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулсан арга хэмжээг зохион байгуулна.	50	9	59	
Зорилт 2"ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ "-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 2.1. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	50	9	59	
2	Арга хэмжээ 2.2 Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэхэд хэлтсийн албан хаагчидтай хамтарч ажилласан байна.	52	9	61	

3	Арга хэмжээ 2.3 ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан байна.	60	10	70	
Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” -ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Арга хэмжээ 3.1 Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	55	9	64	
2	Арга хэмжээ 3.2 Ажлын цаг ашиглалт	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1 Шаардлагатай тохиолдолд үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийг хэрэгжүүлж, тайлагнасан байна.	53	9	62	
Дундаж оноо:				63.2	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Сургалтад хамрагдах.	100	15	
Дундаж оноо:			15	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	6.6	
2.	Асуудал шийдвэрлэх	6.6	
3.	Хариуцлагатай байдал	6.6	
4.	Дүн шинжилгээ хийх	6.6	
5.	Ажлын цаг ашиглалт	6.6	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1. Асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах ур чадвар	6.6	
7	Мэргэжлийн ур чадвар 2. Бүтээлч байдал	6.6	
8	Мэргэжлийн ур чадвар 3. Судалгаа, дүн шинжилгээ, дүгнэлт хийх ур чадвар	6.6	
Дундаж оноо:		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1	Хандлага, ёс зүй	8
2	Багаар ажиллах	8
3	Харилцаа	8
Дундаж оноо: 8		


5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	63.2
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	-
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		92.8

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

 (Д.Цэндсүрэн)

2024.06.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Гаалийн улсын байцаагч

 (Э.Алтанзул)

2024.06.10 (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

(Г.Энхтайван)

2024.07.26 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч


(Ж.Баясгалан)

..... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч:

Гаалийн ерөнхий газрын дарга



(Р.Отгонжаргал)